

**Монголын залуучуудын хөдөлгөөний
түүхийн асуудалд**

Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Болдбаатар

Хүн төрөлхтөний түүх, цадигт үе үеийнхэн: “Одоогийн залуучууд” хэмээн зэмлэх, аргадах хослуулан сургамжилсаар иржээ.

Тэгсэн мөртлөө залуус л дараа дараачийн шинэ эриний эхийг тавьж, шинэ соргог бүхнийг мэдэрч, оройлон манлайлж хэрэгжүүлж байдаг нь хан хорвоогийн жам ёс ажгуу. Өнө мөнхийн оргилуун залуу нас.....Ийм ч учраас Монгол улсын төрийн шагналт ,яруу найрагч Цэгмидийн Гайтав:

Үхэшгүй мөнхийн хорин тавтай

Үлгэрийн баатар Жангар шиг

Үргэлж энхийн цэлмэг байдаг

Үлэмжийн саруул тэнгэр шиг хэмээн залуу насны ид хавыг магтан дуулсан буй заа.

Хатамж төгс Тэмүжин 27 насандаа Хамаг Монголын нэгдлийг дахин сэргээж, хаан Чингис хэмээн өргөмжлөгдөөд, халуун амь, бүлээн цусаа үл хайрлан тэмцэж, Их Монгол улс байгуулснаа хотол даяар зарлан тунхагласан юм. XX зууны эхэн үед Монгол үндэстний тусгаар тогтнолыг дахин сэргээж , сэргэн мандалтын эхийг тавигсад мөнөөх л 20,30-аад насны залуус байлаа.

**I. Залуучуудын хөдөлгөөний үүсэл,
нам, эвлэлийн зөрөлдөөн**

Хүн төрөлхтөн улс төрийн нам, хөдөлгөөн, тэмцлийн баялаг намтартайгаар XX зууны босгыг алхсан билээ. Залуу үеийнхэн нам, хөдөлгөөний шаштир түүхийг бичилцэхийн хамт хүн амын хамгийн эрчим тэмүүлэлтэй бүлгийн хувьд залуучуудын хэмээх өөрийн гэсэн зохион байгуулалттай, бие даасан хөдөлгөөнийг бий болгожээ.

Дэлхий дахиныг хамарсан тэр хөдөлгөөнөөс Монголын залуучууд ч хоцорсонгүй. Тэд 1921 оны Үндэсний ардчилсан хувьсгалыг оройлж манлайлан, тэр ондоо Монголын залуучуудын хөдөлгөөний бүтэц, зохион байгуулалтын тулгын чулууг тулж, гал голомтоо бадраасан юм. 1921 оны VIII сарын 25-ны өдөр Гүрсэд, Жадамба, Содном, Янжмаа нарын 17 хүний бүрэлдэхүүнтэйгээр Монголын Залуучуудын анхны байгууллагыг үүсгэн, тэрлэж, эхэлжээ.

Монголын залуучуудын байгууллага тухай тэрхүү хэсэг залуусын саналтай Д.Сүхбаатар танилцаж, дэмжин гарын үсэг зураад МАН-ын Төв Хороонд оруулахаар зөвлөсөн байна. /1,14/

Залуучууд өөрсдийнхөө үүсгэн тэрлэсэн байгууллагыг “Бошгыг халах залуучуудын эвлэл” гэж нэрлэжээ. Гэтэл Төв Хорооны дарга С.Данзан залуучуудын байгууллагад бичиг хэргийн зардал өгөхөөс цааргалж байв. Үүнээс С.Данзан болон залуучуудын байгууллагын хооронд зөрчил үүсч эхэлсэн байна.

Монголын залуучуудын байгууллага үүсэн байгуулагдсан үеэсээ монгол зоныг гэгээрүүлэх, соёлжуулах үйлсэд хүчин зүтгэж, улс төрийн бие даасан үйл ажиллагаа явуулж эхэлжээ. 1922 онд хуралдсан Монголын Залуучуудын байгууллагын анхдугаар их хурал “Бошгыг Халах Залуучуудын Эвлэл” нэрээ сольж , Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл гэж нэрлэсэн байна. Тус хуралд жанжин Д.Сүхбаатар зэрэг нам, төрийн удирдах хүмүүс урилгаар оролцож “...Монголын залуучууд ба түүний хувьсгалын явдал ... Монгол улсын цааз засгийн үндсэн тулгуур байгуулах нь /байгуулахад Ж.Б./ гүнээ холбогдсон учир эдүгээгээс улам улмаар эв хамтлан эрдэм соёлдоон шаламгайлан боловсруулаад /боловсроод Ж.Б./ энх түвшин жаргалангийн үүд баримтлах эрхэм залуучуудын сүр цог жавхлан тунгалаг мандах нар лугаа адил гялбалзах /гялалзах Ж.Б/ болтугай”. /2/ хэмээн ерөөл дэвшүүлжээ. МХЗЭ-ийн I их хурал МАН-ын зорилго нь залуучуудын байгууллагын зорилтод нийцэх тул хоёр этгээд “ ... эл

зорилтоо гүйцэтгэх бүхий л ажил хэрэгт хавсран гүйцэтгэсүгэй" /3,7-8/ гэсэн шийдвэр гаргажээ.

МХЗЭ-ийн ТХ-ны нарийн бичгийн дарга Баваасан, МАН-ын ТХ-ны тэргүүлэгч гишүүн Элбэгдорж Ринчино нар "Нам, эвлэлийн хоорондын хэлхээ холбогдлын тухай" хэмээх баримт бичиг боловсруулж, эхний хоёр зүйлд "Улсын дотоод, гадаад явдлыг МАН-аас удирдан жолоодно", "Залуучуудын эвлэл намын хэрэгт хүчин тусална", "Залуучуудын эвлэл аливаа улс төрийн хэргийг үүсгэхдээ Намын ТХ-гоор уламжлан илэрхийлнэ.", Намын Төв Хороо "Эвлэлийн саналыг зөвшөөрөх аваас тэрхүү саналыг нам ба эвлэлийн өмнөөс Засгийн Газраар гүйцэтгэн явуулахыг оролдоно" гэх мэтээр дурдсаныг С.Буяннэмэх зэрэг МХЗЭ-ийн удирдагчид зөвшөөрөхгүй байжээ. /4,21/

МХЗЭ-ийн II их хурал дээрхи баримт бичгийн үзэл санаа залуучуудын байгууллагын язгуур зорилт, чиг шугамаас гажсан гэж үзэж, түүнийг хэрэгсэхгүй болгожээ.

С.Буяннэмэх нар МХЗЭ-ийг намын нэг хэсэг болгох, зохион байгуулалтын хувьд намд захирагдах, эвлэлийн байгууллагын ажлыг намын байгууллагаас шүүрэн авч хөндлөнгөөс оролцох явдлыг эсэргүүцэж, ХЗЭ-ийн зохион байгуулалтын бие даасан байдлыг хангах, түүнийг улс төрийн хараат бус залуучуудын байгууллага болгохыг эрмэлзэж байв. Гэвч энэхүү зөв чиглэл бүхий хандлагыг Коминтерний зүгээс КИМ буюу залуучуудын Коммунист интернационалаар дамжуулан хэт хөөрөгдөж, МАН-тай өрсөлдөгч улс төрийн сөрөг хүчин бий болгох оролдлого хийх болсон байна.

Залуучуудын байгууллага үндсэн чиг шугамаасаа гажиж хэт хувьсгалчирхах замд шилжин, МАН язгууртны этгээд лүгээ нэгдэж, үндсэн зорилгоос огооров, Засгийн газар харилцан зохицож, эрхээ хуваарилав гэх зэргээр хурц шүүмжлэл өрнүүлэх болжээ. Хүн амыг анги, бүлгээр ялгаварлахгүй байх, үндэсний эв нэгдлийг эрхэмлэх талаар МАН-аас баримталж байсан байр суурийг тэд эсэргүүцээр байсан төдийгүй МАН-ын дотоод үйл хэрэгт шууд хутгалдах болсон юм. Энэ нь МАН-ын II, III их хуралд ХЗЭ-ийн гишүүдийг суулгаж, хурлын шийдвэрт нөлөөлөх оролдлого хийж байсан болон МАН-ын II их хурал зарим үед хамтарсан хуралдаан хийсэн зэргээр илэрч байв.

Нөхцөл байдал даамжирч байсан учир МАН-ын Төв Хороо 1924 оны VI сарын 29-ний өдөр КИГХ-ны Дорнодын хэлтэст захидал бичиж, байр сууриа илэрхийлсэн байна. Ил захидал МХЗЭ, КИМ-ийн удирдамжаар "Ардын намтай өрсөлдөгч шинэ нам байгуулах гэсэн тодорхой шугам баримтлах болсон"-ыг /5,63/ тэмдэглээд, Коминтернд багтдаг атлаа КИМ-д үл илтэнэ гэдэг бол даан ч зохимжгүй зүйл мөн" хэмээн дурдаж, нам, эвлэлийн зөрөлдөөний асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүсчээ. Коминтерний Гүйцэтгэх Хороо асуудлыг хэлэлцээд, МХЗЭ-ийн намтай зөрчилдөж байгааг зогсоох, намын удирдах үүргийг дээшлүүлэх тухай тогтоол гаргажээ.

Энэ тогтоолыг МАХН хүлээн авсны дараахан ХЗЭ-ийн удирдах зүтгэлтнүүд Засгийн газрын нарийн бичгийн дарга Баваасан, МХЗЭ-ийн ТХ-ны дарга Буяннэмэх нарын зэрэг МХЗЭ-ийн удирдлагад нэр нөлөөтэй хүмүүсийг тусгаарлаж хорьсон байна. Энэ нь МАН-ын III их хуралдаж байсан үе бөгөөд тус хурлыг даргалж байсан С.Данзан дээрхи үйлдлийг эрс эсэргүүцэж, хуралд цаашид оролцохоос татгалзсан байна. Дамбадорж, Элбэгдорж Ринчино нар Данзанд хувьсгалын эсэргүү хэмээх ял тулгаж, улмаар Данзан, Баваасан нарыг баривчлан гянданд хорьж, дараа нь цаазалжээ. Намын III их хурлын төлөөлөгчид тэдний ялын тогтоолыг батлаагүйгээр барахгүй, хөнгөн гоомой хэрэг үйлдлээ хэмээн дургүйцлээ илэрхийлсэн байна.

1924 оны IX сарын 15-30-нд хуралдсан МХЗЭ-ийн III их хурлаас гаргасан тогтоолд: МХЗЭ-ийн ТХ-ны Тэргүүлэгчид Данзан зэрэг баруунтныг дэмжиж, МХЗЭ-ийг тусгай нам болгохыг оролдсон, нам, эвлэлийн хэлхээ холбоог алдагдуулахад хүргэсэн, Данзанг ерөнхий сайдаар томилох буруу санал гаргаж, улсын удирдлагыг хөрөнгөтний гарт оруулахыг хичээсэн хэмээн тэмдэглэжээ. Ийнхүү нам, эвлэлийн зөрөлдөөний асуудлыг шийдвэрлэж дууссан байна.

II. МАХН-ын дайчин туслагч, бэлтгэл хүч

МХЗЭ, эрх баригч намын хооронд үзэл баримтлал, ажил төрлийн зарим зөрчил байсан боловч, бүтэц, зохион байгуулалтын хувьд өргөжин бэхжиж, үйл ажиллагааны цар хүрээ өсч байв. 1921 оны IX сард МАН, Ардын засгийн газраас эвлэлийн эгнээг өргөтгөх, төв суурин, орон нутагт Бошгыг халах залуучуудын эвлэлийн үүр байгуулах явдлыг дэмжсэн шийдвэр гаргажээ. Орон нутагт залуучуудын байгууллага байгуулагдсаныг дэмжиж, гэр бэлэглэж байсан нь соёл хүмүүжлийн ажлын төв “Улаан гэр”-ийн үүсвэр болжээ. Нийслэл хотын ХЗЭ-ийн үүр, гишүүдийн тоо олширч, өргөжсөнөөр 1923 онд Улаанбаатар хотын ХЗЭ-ийн хороо байгуулагджээ.

1921-1924 онд МХЗЭ-ийн 3 удаагийн их хурал хуралдаж, хот, хөдөөд олон үүр, хороо байгуулагдан, 5000 шахам гишүүнтэй болжээ. 1923 оны VIII сарын 16-нд МХЗЭ-ийн анхны хэвлэл “Манай зам” сэтгүүлийн анхны дугаарт “Эзэрхэг эрхэнд эргүү балмадаар доромжлон дарлагдсан идэрчүүд эрх чөлөөгөө олж хөгжин мандтугай” гэсэн бичиг бүхий хавтастэй хэвлэгдэн гарчээ. Түүнчлэн залуучуудын байгууллагын анхны сонин 1924 оны III сарын 26-нд “Манай үнэн” нэртэйгээр хэвлэгдсэн байна. Эдгээр хэвлэлүүд өргөн олон, залуучуудын дунд шинэ цагийн суртлыг дэлгэрүүлэгч салхич шувуун болж байв.

1922 оны өвөл МХЗЭ-ийн ТХ-ны дарга С.Буяннэмэх Москва хотноо хуралдсан алс дорнодын ард түмэн залуучуудын I их хуралд оролцож, В.И. Ленинтэй уулзсан нь тус байгууллага олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж эхэлсэн анхны гараа байлаа.

Шинэ Монголын залуучуудын байгууллага, гишүүд эрдэм билэг, ухааны цараа сорьж, хүүхэд, залуучууд, юуны өмнө өөрийнхөө гишүүдийг сурган боловсруулах үйлсийг манлайлж байсан юм. Залуучуудын байгууллага дөнгөж байгуулагдмагц 1921 оны VIII сарын 28-ны өдрийнхөө хурлаар хөвгүүд, охидыг бичиг эрдэм, торго, торгомсог зүйл нэхэх элдэв үйлдвэрийн сургууль байгуулъя хэмээн хэл бичгийн сургууль байгуулж, аймаг, шавиас багачуудыг татан ирүүлж, бичиг эрдэмд сургах нь эвлэлийн байгууллагын нэн тэргүүний зорилт гэж үзжээ. Энэ дагуу МХЗЭ-ээс хүн амыг бичиг үсэгт сургах хөдөлгөөн өрнүүлж, хот, хөдөөд иргэний бага сургууль байгуулах явдлыг бүх талаар дэмжиж байв.

1924 оны эцэс гэхэд залуучуудын байгууллага МАХН-тай зөрчилдөхөө больж, намын дайчин туслагч, бэлтгэл хүчний үүрэг гүйцэтгэж эхэлжээ. 1928 оны V сарын байдлаар МХЗЭ 7000 орчим гишүүнтэй болсон байв. Гадаадад сурч байгаа оюутнууд ч ХЗЭ-ийн үүр байгуулж байлаа. Тухайлбал 1925 онд Москвагийн Дорно дахины дээд сургуулийн Монгол оюутнууд Д.Сүхбаатарын нэрэмжит ХЗЭ-ийн 74-р үүр байгуулжээ.

МХЗЭ-ийн III их хурлын шийдвэрээр залуучуудыг бичиг үсэгт сургах ажил эрчимжжээ. 1923 оны XII сард МХЗЭ-ийн ТХ-ны бүсгүйчүүдийн тасгийн дарга, номын багшаар Чимэдцэрэнг томилж, эмэгтэй гишүүдэд тусгайлан бичиг үсэг зааж байсан нь “Эрийн зарц, гэрийн боол” мэт байсан Монголын эмэгтэйчүүдийг соён гэгээрүүлэх үйлсэд залуучуудын байгууллага томхон үүрэг гүйцэтгэж эхэлсэн хэрэг юм. 1928 оны дунд үе гэхэд ХЗЭ-ийн нийт гишүүдийн 60 орчим хувь нь бичиг үсэгтэй буюу анхан шатны мэдэгдэхүүнтэй болжээ.

1925 он МХЗЭ-ийн түүхэн замналын хуудсыг нэгэн шинэ үйл явдлаар баяжуулсан юм. Энэ оны V сарын 8-нд Монголын шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч Д.Нацагдоржийн санаачлагаар Улаанбаатар хотын “Хүрээ танхим” хэмээх бага сургууль дээр “Хойчийг залгамжлагч багачуудын холбоо” нэртэйгээр пионерийн байгууллагын үндэс суурийг тавьсан байна. Анхны цугларалтанд оролцсон хүүхдүүдэд “Бүхий олон багачууд” дууг монгол ардын “Хотгойдын унага” дуунд ая оруулан заасан бөгөөд сүүлд нь Магсар хурцын Дугаржав энэ дууны ая донжийг найруулан зохиожээ. Тэр үеийн “Үнэн” сонинд: “... тэрхүү пионер хэмээх багачуудын холбоо байгуулсан нь нэн гайхаж биширмээр болой. Ямар хэмээвээс мөнхүү холбоонд орсон багачууд 8-15 нас хүртлэх хөвгүүд, охид бөгөөд өмссөн хувцас Европын боловсон байдалтай. Цагаан цамц, хөлийн өвдгөөс дээш гарсан хөх өнгийн өмд, дүгрэг бүсэн малгай өмссөн нь нэгэн жигд, ив

ижилхэн. Явж жагсахад тэдгээр хүүхдүүдийн нурууны өндөр богинын байдлаар тэнцүүлэн эхэн түрүүнд өндөр нуруутайг жагсааваас, дараад бага нуруутайг жагсаах зэргээр дэс дэслэн зэрэгцүүлж, мөнхүү жагсаалын түрүүнд тэрхүү хүүхдээс хэд нь хөгжим, бүрээ үлээн бусад нь дуу аялж, цэргийн сургуулийн жагсаалаар явж Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны өмнө ирж ёслоход Засгийн газраас баяр хүргэжээ." /6/ хэмээн бичжээ.

Пионерийн байгууллагаас "Олон улсын хүүхдийн 7 хоног", хот цэвэрлэх "Хөдөлмөрийн 7 хоног" ,Зөвлөлт, Монголын пионерийн отрядын хамтарсан найрамдал нөхөрлөлийн сэдэвт олон төрлийн ажил зохиосон байна. 1926 онд пионерийн байгууллагын анхны хэвлэл-"Залгамжлагч" сэтгүүлийн анхны дугаар хэвлэгдэн гарсан байна.

МАХН-ын Төв Хороо ард түмнийг гэгээрүүлэх, соёлжуулах, урлаг утга зохиолыг хөгжүүлэх явдлыг МХЗЭ-д даалгасан тогтоол гаргаж, авьяас төгөлдөр залуучуудаас бүрдсэн "Жүжгийн хүрээлэн" байгуулах нь зүйтэй гэж үзжээ. Д.Нацагдорж, С.Буяннэмэх нарын хэсэг залуус, Нийслэл хүрээний орос цэргийн клубт сургуулилан анхны тоглолтоо хийснээр орчин үеийн Монголын шинэ соёл урлагийн эхлэлийг тавьсан байна.

1926 оны YII сард ардын хувьсгалын 5 жилийн ойгоор Залуучуудын биеийн тамирын тоглолт бэлтгэж үзүүлсэн нь тухайн үедээ нэлээд шинэ соргог содон сонин зүйл байв. Мөн үеэс "Улаан булан" нэртэй ухуулга, сурталчилагаа хийх болж, мориор аялан нүүдлийн жүжиг тоглож, түүний орлогоор МХЗЭ-ийн ТХ-г санхүүжүүлж байжээ.

1920-иод оны сүүлчээр залуу яруу найрагч, эмэгтэй Цэрэнлхам "Эмэгтэйчүүдийн дуу" зохиож

Хүмүүн төрөлхтөн дотроосоо

Хүнд бэрхээр дарлагдсан

Хөөрхий бидний бүсгүйчүүд

Хүмүүжих замыг дагацгаав... хэмээн бичсэн нь хүний наад захын эрх, эрх чөлөөг үл мэдэрч байсан монгол эмэгтэйчүүдийг шинэ амьдралд уриалан дууджээ.

Улс ардын аж ахуй, эдийн засгийн амьдралд ч залуучуудыг оролцуулах талаар ХЗЭ-ийн байгууллагууд багагүй зүйл хийж байв. 1926-1927 онд Налайхын нүүрсний уурхай, Улаанбаатарын цахилгаан станцийг өргөтгөж, мод боловсруулах үйлдвэр, туйпууны завод, төмрийн завод, улсын авто ба ардын тээврийн хэрэг эрхлэх газар, гар урчуудын артель зэргийг байгуулахад эвлэлийн гишүүд, залуучууд бусдыг уриалан идэвхитэй оролцон манлайлжээ.

III. Зүүний алдаа завхрал ба залуус

1920-иод оны дунд үеэс Коминтерн МАХН-ын үндэсний ардчилсан чиг шугамыг хянан засварлах замд шилжжээ. Коминтерний зүгээс идэвхитэй явуулга хийж, МАХН-ын удирдлагад хөдөө нутгаас дэвшиж ажилласан залуучуудыг үндэсний ардчилсан үзэлтнүүдийн эсрэг турхирсан байна. Үндэсний ардчилсан чиг шугам баримтлагчдад "Баруунтан" гэсэн нэр хоч өгч, 1928 онд хуралдсан МАХН-ын YII их хурлаар бут цохисон байна. Ингэж Коминтерн Монгол оронд зөвлөлт маягийн социализмыг байгуулах туршилт хийх замд оржээ.

1929-1930 оны үеэс Монгол оронд зүүний нугалаа завхрал газар авчээ.. Тус оронд социализмыг яаравчлан байгуулах МАХН-ын чиг шугамыг МХЗЭ идэвхитэй дэмжиж, гишүүд нь хэт хувьсгалчирхах, ангичирхах замд шилжсэн байна. Үүнийг МХЗЭ-ийн YIII их хурлын төлөөлөгчдийн шүүмжлэлээс харж болно. Төлөөлөгч Батнягт: "Элдэв-Очирын эхнэр Туваансүрэн бол гарцаагүй феодал мөн. Манай үүр Туваансүрэнг эвлэлээс хөөж, нөхөр Элдэв-Очирыг түүнээс салахыг шаардсан. Гэтэл Элдэв-Очир эхнэрээ өмөөрч...намайг эхнэрээс салахыг шаардах эрх та нарт байхгүй гэж хэгжүүрхсэн. Сургуульд хүүхдийг нь авахдаа ангийн шугамыг баримтлахгүй байна. Тухайлбал Данзангийн охинийг сургуульд авчээ" гэж зэмлэж байхад төлөөлөгч Лувсан: "Цагаан сар бол феодалын баяр мөн... Энэ жил цагаан сар тэмдэглэхийг хорьсон боловч айлууд тэмдэглэсээр байгаа нь орон нутгийн удирдлагуудын дутагдал мөн." хэмээн

шүүмжилжээ. Төлөөлөгч Шагдарсүрэн: "Герман, Францад сургуульд явуулсан залуусаа яаралтай буцааж дуудвал зохино. Тэд бидэнд ямар ч ашиг өгөхгүй" гэж хэлсэн байна. Төлөөлөгч Сампилноров: "Эвлэлийн удирдах ажилтан Содном мэтийн феодал байсаар байна. Довчинбазар феодал, Дашдэмбэрэл оппортунист" /7/ гэх мэтээр ярьжээ. Энэ нь эвлэлийн улс төр, гэгээрлийн ажлын нийтлэг төрх болж байв. Хөдөө нутагт "хар фийдаал" гэж хашгирч сүржигнэсэн залуус олширч, хот суурин газар нэгэн ижил хувцас өмссөн анги, намын байр суурь хэмээн улс төрийн том том үг ярьсан залуус олон болж, тэд сүсэгтний бурхан тахилыг хураах, сүм хийдийг бусниулах, хов жив цуглуулах зэргээр хувьсгалчирхах болов.

Залуучууд Коминтерн, КИМ-ийн хөөргөл, дэвэргэлтэнд автан, феодалын хөрөнгө хураах, хамтралжуулах, компанит ажлыг манлайлж байлаа. Хот, хөдөөд феодалын хөрөнгө хураах комисст ХЗЭ-ийн 400 шахам гишүүд ажиллаж, язгуур угсаа бүхий баян, чинээлэг хэсгийн олон жилийн турш өөрсдөөсөө ч харамлан зүтгэж байж хуримтлуулсан мал сүрэг, өмч хөрөнгөд эрээ цээргүй халдаж, хүний өмчлөх эрхийг хамгийн ноцтой зөрчиж байгаагаа үл ухамсарлан, тэрхүү үйлдлээ шинэ нийгэм байгуулахад чухал хувь нэмэр оруулж байна гэж ойлгон зүтгэж байв.

Тэр үеийн удирдах зүтгэлтнүүд, түүний дотор залуучуудын байгууллагын удирдах хүмүүс бие биенээсээ илүү олон хамтрал байгуулж, "гавьяа зүтгэлээ" үнэлүүлэх гэж өрсөлдөцгөөнө. Тэд сайн сайхан үйлсийн хоосон мөрөөдөлд автаж, социализмыг яаравчлан байгуулбал хэм тэгш жаргана хэмээн итгэж, найдаж байв. Гэвч хүсэл мөрөөдөл талаар өнгөрч, Монголын нийгмийг гүн хямралын ангал руу хөтөлсөн билээ.

Монголын нийгэмд улс төрийн тогтвортой байдал алдагдаж, ялангуяа урьд хилийн дагуух болон түүнтэй ойролцоох аймгуудад зүүний нугалаа завхралд дургүйцсэн энгийн ардууд нүүж дүрвэх хөдөлгөөн гарчээ. Ийм хүнд нөхцөлд зүүний нугалаа, завхралын шалтгаан, утга холбогдол, элгэн халуун эх нутаг хичнээн үнэ цэнэтэй, эрхэм болохыг дүрвэгсэдэд ойлгуулах хэрэгт ХЗЭ-ийн гишүүд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Үүний үр дүн ч гарч зарим өрх айлууд эх нутагтаа үлджээ. Гэвч учрыг ойлгохыг үл хүсэж бухимдсан зарим хэсэг нь нам, эвлэлийн ажилтнуудын эсрэг шууд дайсагнаж байлаа. Тэдэнд учрыг нь ойлгуулах талаар уйгагүй ухуулга, ятгалга хийж, эцэст нь баригдан тамлагдаж эрэлхэг баатарлагаар тэмцэгчдийн нэг нь ХЗЭ-ийн 372-р үүрийн дарга, 19 настай Түвдэнгийн Бор байлаа. Хожим 1963 онд АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар Өмнөговь аймгийн Цогтцөций суманд Түвдэнгийн Борын дурсгалын хөшөөг босгож, МХЗЭ-ийн 50 жилийн ойгоор улсын баатар цол нөхөн олгож мөнхжүүлжээ.

1930-1932 онд баруун болон төвийн аймгуудыг хамарсан лам, ардын бослогыг дарах хэрэгт ХЗЭ-ийн гишүүд, залуучууд гол үүрэг гүйцэтгэсэн байна.

1931 онд Ардын хувьсгалын 10 жилийн ойг тохиолдуулан, ардын төрийг бэхжүүлэх, эх орныхоо тусгаар тогтнолыг хамгаалах, хувьсгалыг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд гарамгай гавьяа байгуулсаны учир МХЗЭ-ийг "Байлдааны гавьяаны улаан тугийн одон"-гоор шагнажээ.

Зүүний нугалаа завхралд залуучууд идэвхийлэн оролцож байсан боловч, хэрэг бишдсэнийг анх түрүүн мэдэрч, засаж залруулах арга зам анхлан эрэлхийлэгчид мөн л залуучууд байлаа.

IV. Шинэ эргэлтийн бодлого ба залуучууд

1932 оны VI сарын сүүлчээр хуралдсан МАХН-ын ТХ, Хянан Шалгах Төв Комиссын хамтарсан онц III бүгд хурал зүүний нугалаа завхралыг засах шийдвэр гаргаж, түүхэнд "Шинэ эргэлтийн бодлого" хэмээн алдаршчээ. Шинэ эргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд МХЗЭ-ийн гишүүд, нийт залуучууд томоохон үүрэг гүйцэтгэсэн юм.

ХЗЭ-ийн байгууллагууд шинэ эргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд МХЗЭ-ийн гишүүд, нийт залуучуудын хүчийг дайчилжээ. ХЗЭ-ийн байгууллагууд шинэ эргэлтийн бодлогыг сурталчлах, нам, засгийн тогтоол, хууль дүрэм, нам, улсын түүх судлах, бүлгэм байгуулан хичээллүүлж, биеийн тамир, уран сайхны дугуйланд залуучуудыг хамруулж

байв. Эвлэлийн гишүүдийг бичиг үсэгт сургахын зэрэгцээ, төв суурин газруудад дугуйлан байгуулж, бичиг үсэг, номтой гишүүдийг багшаар ажиллуулах болов.

1934 онд хуралдсан МХЗЭ-ийн IX их хурал: "Хувьсгалт залуучуудын эвлэл нь ардын залуучуудын улс төрийн байгууллага үнэхээр болж, тэрхүү залуучуудыг зохион байгуулагч ба удирдагч нь" /8,367 гэж заажээ.

Залуучууд шинэ нийгмийн бүтээн байгуулалтыг манлайлж байлаа. Аж үйлдвэрийн комбинат, Хатгалын ноос угаах фабрик, Төв цахилгаан станц зэрэг орчин үеийн аж үйлдвэрийн суурийг тавихад МХЗЭ-ийн гишүүд, санаачлагаараа очиж, анхны ажилтан нь болж, шинэ залуу ажилчин ангийг бүрдүүлж байв.

Шинэ эргэлтийн бодлогын амин сүнс болж байсан ардын хувийн аж ахуйтны мал өсгөх сонирхлыг дээшлүүлэх, таваар мөнгөний харилцааг хөгжүүлэх үйлсэд МХЗЭ-ийн байгууллага, гишүүд хамгийн идэвхи чармайлттай оролцсон юм. Улс орны хөгжилд МХЗЭ-ийн оруусан хувь нэмрийг өндөр үнэлж, 1939 онд Хөдөлмөрийн Гавьяаны улаан тугийн одонгоор шагнажээ.

Улс орны эдийн засгийн амьдралын илт сэргэлт, үндэсний ардчилсан чиг шугамын хэрэгжилт нь туйлширсан коммунист үзэл, улс төрийн нийтээр хоморголон хэлмэгдүүлэлтийн балгаар тасалджээ. 30 шахам мянган хүн хилсээр хэлмэгдсэний дийлэнхи олонхи нь идэр залуу үеийнхэн байсан юм. Яагаад гэвэл тэр үеийн Монголын залуус үнэнийг сөрөн зогсож, худлыг хуйхлах зориг, ухаан төгөлдөр байсанд хэрэг явдлын гол учир оршино.

Тэд үнэний төлөө, улс Монголынхоо төлөө халуун амиа золиосолж байв. Ийнхүү залуусын нэг хэсэг нь ямар ч гэм зэмгүй мөртлөө улс төрийн бодлогын золиос болж байхад нөгөө хэсэг нь амь насаа огоорон улс Монголынхоо бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг хамгаалан Халх голд харийн дайсантай тулалдаж байсан юм.

1936 оны Булан дэрсний тулалдаанаас Шагдарын Гонгор, Халх голын байлдаанаас Лодонгийн Дандар, Цэндийн Олзвой, Дамчайн Дэмбэрэл, Чоймболын Шагдарсүрэн, Даржаагийн Хаянхярваа нарын эх орончид МХЗЭ-ийн бат илэрхийлэх өвөртлөн үсрэх сум, тэсрэх бөмбөгийг сөрөн эрэлхэг баатарлагаар тулалдаж, Улсын баатар цолоор шагнагдсан бөлгөө. Энэхүү зоригт дайчдын гавьяа Монгол найрагчийн онгодыг хөглөн:

Цэлмэг залуу насныхаа гал дөлөөр бадарч

Сэтгэл зүрх хоёртоо шатаж явах үедээ

Чин үнэнч амрагтаа хэлж үзээгүй мөртлөө

Чиний төлөө үхье гэж эх орондоо хэлдэг гэсэн сайн үгсийн ороог барьж, утгын чимэг зохиролдуулсан яруу бадаг цээж дэлдэн ундраа буй заа.

V. Дэлхийн II дайны жилүүдэд Монголын залуучууд

Монголын нийгэм улс төрийн хэлмэгдүүлэлт, Халх голын дайн зэрэг зовиур бэхшээлийг амссаар 1940 оны босгыг алхжээ. 1940 онд МАХН-ын X, Улсын VIII их хурал хуралдаж, И.В.Сталин, Х.Чойбалсан нарыг тахин шүтэж байсны улмаас тус улсын мал сүргийн тоо толгойг 200 мянгад хүргэх үл гүйцэлдэх зорилт дэвшүүлсэн юм. Залуучуудын байгууллагын зарим удирдах ажилтан малыг 200 саяд хүргэх асуудлыг дэвшүүлэн тавих гэж байхад бодитой хандаж байв. Тухайлбал МХЗЭ-ийн ТХ-ны нарийн бичгийн дарга Сэнгэдорж нэг малд ногдох газар, бэлчээр, мал өсөж үржих хүчин зүйлийг тооцоолж, 200 саяд хүрэх ямар ч боломжгүй гэдгийг маршал Х.Чойбалсан хэлэхэд :

- Бид нар намын X их хурал болох гэж байхад нөхөр Сталинаас хэрхэвч зөрг болохгүй. Та нар хийдэг ажлаа хийж бай хэмээн дургүйцжээ. /9,31/ Сэнгэдорж үнэний төлөө явсныхаа "гор-ыг амсаж ,удалгүй хилс хэргээр баригдан хэлмэгджээ.

ХЗЭ-ийн гишүүд, залуучууд, эрх баригч намын бодлого, шийдвэрт гүнээ итгэж, амьдралд хэрэгжүүлэхийн төлөө залуу насны ид хав, эрчим чадлаа зориулж байлаа. "Залуучуудын эвлэлийг мал аж ахуйг хөгжүүлэх тийш хандуулах гэсэн зорилго нь бүх залуучуудыг өөр ажил хийхгүйгээр цөм хөдөө гарч мал хариулсугай гэсэн хэрэг гэж үл ойлгож болно. Энэ нь залуучуудыг үнэхээр малд хайртай, мал аж ахуйч болгох гэсэн

хэрэг юм" /10/ гэж МХЗЭ-ийн ТХ-ны IY бүгд хурлын илтгэлд онцлон тэмдэглэжээ. Ингээд залуучуудын байгууллагын ажлыг малын тоо толгойг өсгөх, мал аж ахуйн дотоод нөөц бололцоог аль болох бүрэн дайчлан ашиглахад чиглүүлсэн байна.

Ялангуяа 1940 онд намаас дэвшүүлсэн "Ноос бол алт" гэсэн уриаг ХЗЭ-ийн байгууллага, залуучууд дэмжин хүлээн авч, ноос ноолуур арвин ихээр бэлтгэх, түүнийг бүрэн ашиглах зорилгоор "Хаягдал ноос түүцгээ" гэсэн уриан дор ажиллаж байв.

1940 оны I сард МХЗЭ-ийн Төв Хороо "Аж үйлдвэрийн комбинатийн.... ажилчдыг гүйцээх арга хэмжээний тухай" тогтоол гаргаж, ажилчдын эгнээг ХЗЭ-ийн гишүүд, залуучуудаар өргөтгөв.

1941 оны YI сарын 22-нд Гитлерийн Герман ЗХУ-д гэнэт халдан довтолж, хүн төрөлхтөний түүхэн дэх хамгийн гамшигт жилүүд нүүрлэсэн юм. "Бүхнийг фронтод" гэсэн уриан дор улс орон даяар зөвлөлтийн ард түмэнд туслах хөдөлгөөн өрнүүлэв. Эвлэлийн гишүүд, залуучууд бүх хүчээ дайчлан оролцож, ажлын зав чөлөөнд субботник хийж мөнгө хуримтлуулах, эвлэлийн нэрэмжит гавшгай отрядууд байгуулан, норм төлөвлөгөө давуулан биелүүлэх, ангийн бригад зохион байгуулах зэргээр ажиллаж байв. Дайны жилүүдэд ХЗЭ-ийн байгууллагын үзэл суртал, хүмүүжлийн ажил залуу үеийг цэрэг эх оронч хүмүүжил төлөвшүүлэхэд чиглэгдэж байв. Дайны жилүүдэд Монголын ард түмэн 700 гаруй вагон, дулаан хувцас, хүнсний зүйл, хувийн бэлэг бэлтгэж, 32 мянган шилдэг морио бэлэглэн, хагас сая шахам морийг хямд үнээр худалдан, "Хувьсгалт Монгол" танкийн бригад, "Монгол ард" нисэх онгоцны эскадрилийг өөрийн хөрөнгөөр байгуулж, улаан армид хүлээлгэн өгчээ. Тухайлбал Октябрийн хувьсгалын 25 жилийн ойгоор ХЗЭ-ийн гишүүдийн бэлгийн II цувааг Зөвлөлтийн улаан армид нийлүүлсэн байна. Мөн залуу өсвөр багачуудын цуглуулсан хөрөнгөөр босгосон "МХЗЭ", "Монгол пионер" хэмээх танк "Хувьсгалт Монгол" танкийн 44-р бригадын бүрэлдэхүүнд байж, Берлинг эзлэх, Прагийг чөлөөлөх тулалдаанд оролцсон юм.

Монголын залуучууд дэлхийн II дайныг төгсгөж, алс дорно дахинд дайны голомтыг устган, энх тайван байдал тогтооход үнэтэй хувь нэмэр оруулжээ. 1945 оны чөлөөлөх дайнд Лувсанцэрэнгийн Аюуш, Дашийн Данзанваанчиг, Сангийн Дампил, Магсарын Жанчив, Гоминданы зэвсэгт дээрэмчдийг устгахад алдарт хилчин Лхүнрэвийн Даваадорж, Баянбалын Тэгшээ, Бэгзийн Гиваан, Х.Дамба нар улс орныхоо өмнө цусан гавьяа байгуулсны учир Улсын баатар цолоор шагнагджээ. Ийнхүү хаана залуус байна тэнд ажлын амжилт, зориг баатарлаг үйлс дагалдаж байлаа.

VI. Энх тайвны бүтээн байгуулалт ба залуус

Дайны дараа БНМАУ энх цагийн бүтээн байгуулалтанд шилжин оржээ. Хэдийгээр манай нутаг дэвсгэр дээр дайн болоогүй боловч эдийн засаг, санхүүгийн ихээхэн бэрхшээл учирсан юм. Улс орны эдийн засаг, төвлөрсөн төлөвлөгөөнд шилжсэн байна. 1948 он IY сард хуралдсан МХЗЭ-ийн XI их хурал: "Монголын залуучуудын дайчин зорилго бол анхдугаар 5 жилийн төлөвлөгөөг биелүүлэх явдалд хамгийн хүнд салбар дээр ажиллаж, улс ардын аж ахуй, соёлын тэргүүний эгнээнд явахад оршино." гэж заажээ. Тус их хурал "Залуучууд үйлдвэрт" гэсэн уриа дэвшүүлсэн байна. Олон аймаг суманд аж үйлдвэрт ажиллах хүсэлтэй залуучуудын нэрэмжит бригадуудыг зохион байгуулав. 1947 онд МХЗЭ-ийн ажилчин залуучуудын хэлтэс байгуулан, ажилчин залуучуудын дунд хувьсгалт уралдааныг зохион байгуулах болсон байна. Улсын бүх ажилчдын 20 хувийг эзэлж байсан МХЗЭ-ийн гишүүдээс 100 гаруй залуучууд 1951 онд 3-7 жилийн ажил хийж гарамгай амжилт гаргасан байна. Түүнчлэн "Улсын ударник" цолтой ажилчдын 21,3 хувь нь эвлэлийн гишүүд байлаа. Мөн ХЗЭ-ийн байгууллагууд 1948 оны үйлдвэрлэлийн болон мал өсгөх төлөвлөгөөг хугацаанд нь биелүүлэх эх оронч хөдөлгөөнийг орон даяар өрнүүлжээ.

МХЗЭ-ийн XI их хурал: "ХЗЭ нь өөрийн гишүүдийн дотор бичиг үсэг үл мэдэх явдлыг устгаж, соёлын довтолгоон зохиох" зорилт дэвшүүлжээ. Бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах зорилтыг хэрэгжүүлэхэд эвлэлийн гишүүд, залуучууд оюун билгээ хөвчлөн дайчилсан юм.

МХЗЭ-ийн гадаад харилцаа өргөжив. 1946-1952 онуудад МХЗЭ дэлхийн ардчилсан залуучуудын холбоо, олон улсын оюутны холбооноос зохион байгуулсан 20 шахам арга хэмжээнд оролцжээ.

Монголын залуучууд 1946 онд Прага, 1949 онд Будапешт, 1951 онд Берлин хотуудад болсон дэлхийн залуучууд оюутны их наадмуудад оролцож, авьяас билэг, идэр залуугийн цог жавхаагаа үзүүлсэн юм.

1951 оны VIII сарын 25-нд МХЗЭ-ийн 30 жилийн ойг тохиолдуулан БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар залуу үеийг хүмүүжүүлэх, улс ардын аж ахуй, соёлын бүтээн байгуулалтанд оруулсан хувь нэмэр, гавьяа зүтгэлийг өндөр үнэлж, Д.Сүхбаатарын одонгоор шагнажээ. Энэ нь Монголын залуучуудын хөдөлгөөний түүхэнд бас нэгэн тэмдэглэлт чухал үйл явдал болсон юм.

VII. Залуучууд социалист бүтээн байгуулалтад

1950-иад он бол манай орны түм буман залуусын өрнүүн бүтээлийн бахдам амжилтын жилүүд байлаа. Тус оронд социализмыг дэлгэрэнгүй байгуулах талаар МАХН-аас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх үйлсэд залуус идэвхийлэн оржээ. 1955 онд хуралдсан МХЗЭ-ийн XII их хурал эвлэлийн байгууллагууд "Манай орны улс ардын аж ахуй, соёлыг цаашид хөгжүүлэх, II 5 жилийн төлөвлөгөөг амжилттай биелүүлэх, Монголын залуучууд, хөвгүүд, охидын эх оронч хөдөлмөрийг өрнүүлэхэд чиглүүлэх хэрэгтэй" гэж үзсэн байна. Юуны өмнө, залуучууд ХАА-н бүтээн байгуулалтанд гар бие оролцон шаргуу хөдөлмөрлөжээ. 1955 онд эвлэлийн малчин гишүүдийн 54 хувь нь мал сүргээ төрөл бүр дээр нь өсгөж, хашаа барих, худаг гаргах, улсын төлөвлөгөөт ажлын тал илүүг залуучууд өөрсдийн хүчээр хийсэн байна.

Өвс хадах морин станцуудыг залуучуудын байгууллагууд шөфлэн авч, тэдгээрт ажиллагсадын 70 орчим хувь эвлэлийн илгээлтээр очсон залуучууд байв. Улсын сангийн аж ахуйн хаврын тариалалт, намрын ургац хураалтын ажлын 80 хувь, хүнсний ногооны 70 хувь, хадлан тэжээлийн тал хувийг залуучууд өөрсдийн санаачлагаар гүйцэтгэж, ХАА-н бараг бүх техникийг унаган хурдан хүлэг морьныхоо жолоог залах мэт эзэмшин ажиллаж байлаа. ХЗЭ-ийн байгууллагууд өндөр ургацын баяр тэмдэглэж, хэд хэдэн сум, багийн залуучууд хамтран хөдөлмөрийн алдрын чуулган зохион байгуулах болов. Тэргүүний залуучуудыг алдаршуулах зорилгоор МХЗЭ-ийн ТХ-ны шагнал "Хүндэт тэмдэг"-ийг бий болгожээ.

1950-иад онд Монголын хөдөөгийн залуучууд тухайн цагийн хоёр том үйл явдал болох ардын хувийн аж ахуйтныг хоршоолох, атар газар эзэмшиж, тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үйлсэд идэвхитэй оролцсон байна. 1958 онд ХАА-н тэргүүний залуучуудын анхдугаар чуулган чуулж, малчин залуучууд, хөдөө аж ахуйн мэргэжилтэн залуучуудад хандан уриалга гаргасан байна. Эл уриалгад "Нэгдсэн хүчээрээ ХАА-н салаа мөчир бүрт хөдөлмөрийн өндөр амжилт гаргаж, хамтын хүчний давуу талыг нийтэд амьдрал дээр харуулцгаая. Хүчээ нэгтгэн ажиллагсадын тэргүүн эгнээнд МХЗЭ-ийн гишүүд ямагт их амжилт гаргаж, манлайлан явахыг уриалъя" хэмээн тэмдэглэжээ.

Нэгдэлжих хөдөлгөөнийг зохион байгуулах болон хэрэгжүүлэх үйлсэд ХЗЭ-ийн гишүүд идэвхитэй оролцсон юм. Эерэг, сөрөг харилцан сүлжилдсэн нийгэм-эдийн засаг, улс төр, сэтгэл зүйн нарийн төвөгтэй нөхцөлд өрнөсөн хоршоолох үйл явцад Монголын залуу үеийнхэн сайн үйлс бүтээж байна гэсэн гуниггүй залуу насны өөдрөг үзлээр хандан чин зүтгэлээ гаргасан билээ. Түүнчлэн тэр үед намын уриа, эвлэлийн илгээлт, атар гэсэн үгс амин шүтэлцээтэй байж, атрыг эзэмших явдал залуу үеийнхний нэр төрийн хэрэг болж байлаа.

Алтан тариа халиуруулах, шинэ суурин тосгоныг бүтээн босгох хүсэл мөрөөдөлд автсан мянга, мянган залуус МХЗЭ-ийн илгээлтээр Зэлтэр, Цагааннуур, Дархан, Хэрлэн зэрэг эмнэг онгон хээр талд очиж, атрын анхны шан таталцаж, атар газар эзэмших, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх их аяныг манлайлсан юм. 1959-1961 онд 350 мянган га атар газрыг эзэмшсэнээр тариалангийн талбай 3,5 дахин, үр тариалангийн үйлдвэрлэл 1,6 дахин нэмэгдэж, Монгол орон үр тариаг зөвхөн хэрэглэгч

орон байснаа хилийн чандад гурил экспортлох хэмжээнд хүрч эхэлжээ. Ерөөгийн САА-н тракторч, МХЗЭ-ийн гишүүн Бямбацогт тариаланчдын эгнээнээс БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар хэмээх эрхэм хүндтэй цолыг анх удаа хүртсэн юм. Түүнчлэн Хэнтий аймгийн Биндэр сумын саальчин, МХЗЭ-ийн гишүүн Цэвэлмаа саалийн 15 үнээнээс жилд 1500 л сүү сааж, 18-хан насандаа Сүхбаатарын одон хүртэж, АИХ-ын депутатаар сонгогдож байхад Өвөрхангай аймгийн Богд сумын тэмээчин Рэнцэнгийн Түвдэн 18 насандаа Сүхбаатарын одонгоор энгэрээ мялааж, залуу үеийнхний бахархал, үлгэр дууриал болж байв.

Ажилчин залуучууд "Өнөөдөр өчигдрөөс илүү, маргааш өнөөдрөөс илүү ихийг сурч ажиллацгаая" гэсэн уриа дор ажиллаж, бүтээн байгуулах их үйлсийн тэргүүн эгнээнд явж байлаа. Залуус бүтээн байгуулалтанд нийгэм олны эрч хүч, урам зоригийг бадраах чиглэлээр олон шинэ санал, санаачлага гаргаж байв. Тухайлбал 1959 онд "Улаанбаатар" төмөр замын илчит тэргэний засварын газрын хэсэг залуучууд социалист хөдөлмөрийн бригадын хөдөлгөөнийг санаачилжээ. Энэ хөдөлгөөн оюутан, сэхээтэн, сурагчдын дунд "Сэхээтний социалист нөхөрлөл", "Оюутан, сурагчдын соёлч нөхөрлөл" зэрэг хэлбэрээр өргөжин тэлжээ. Социалист ёсоор ажиллаж сурч амьдрах чин хүсэл эрмэлзлэл МХЗЭ-ийн гишүүд, залуучуудын гол уриа болсоор байлаа. ХЗЭ-ийн гишүүдийн дотроос Цогоо, Мандах, Отгонцагаан, Гүндсамбуу, Нацагдорж зэрэг хүмүүс социалист хөдөлмөрийн хөдөлгөөнийг үүсгэн санаачилж, хөдөлмөрийн гарамгай амжилт гаргасны төлөө хөдөлмөрийн баатар цол хүртжээ. Энэ үед Монголын залуучууд бичиг үсэг үл мэдэх явдлыг устгах хөдөлгөөн өрнүүлж, соёлын довтолгоон явуулсан юм. Соёлын довтолгооны явцад хэт захиргаадах, нугалах, сүржигнэх явдал гарч байсан хэдий ч бүх нийтийг бичигтэн болгох, ахуйд соёл нэвтрүүлэх талаар мэдэгдэхүйц том алхам хийсэн билээ. 1960 онд Монголын залуучуудын ордонг барьж дуусган, түүний нээлтэнд Ю.Цэдэнбал тэргүүтэй нам, засгийн удирдагчид оролцсон байна. Ийнхүү Монголын залуучууд бүтээн байгуулалтын үйл хэрэгт:

Улаан туг ,залуучууд хоёр ихэр юм

Уралдаан ,ялалт хоёрын нөхөр юм

Манай өнөөдрийн золбоо юм

Маргааш өдрийн гялбаа юм /11,19/ хэмээн дэврүүн сэтгэлээр дуулж, урам зоригтой хөдөлмөрлөж байв.

1950-иад онд нэг хүнийг тахин шүтэж байсны хор холбогдлыг арилгах, нийгмийн амьдралыг ардчилах уур амьсгал бий болгох тухайд Монголын залуу сэхээтнүүд чухал үүрэг гүйцэтгэжээ. Тухайн цагийн МХЗЭ-ийн Төв хорооны I нарийн бичгийн дарга Н.Дангаасүрэн, Эвлэлийн Төв Хорооны хариуцлагатай ажилтан Жамц нарын зэрэг хүмүүс Х.Чойбалсанг тахин шүтэж байсны хор уршгийг үндсээр нь илрүүлэн арилгах олон ургальч үзлийг дэлгэрүүлж, сонгуулийг жинхэнэ ардчилалын үндсэн дээр явуулах, эх орныхоо түүх, соёлыг гүнзгий судлах ,ашигтай бол хэнтэй ч, нэн ялангуяа хөрөнгөтөн орнуудтай худалдаа хийх гэх зэрэг улс Монголоо гэсэн чухал санал гаргасан боловч, "Сэхээтний төөрөгдөл" гэгчид өртөж, үндсэрхэг, үгүйсгэх үзэлтний дансанд орж, хавчигдан хяагдах болжээ. /12/

Монголын залуучуудын байгууллагын гадаад харилцаа өргөжиж, тив дэлхийн олон орны залуучуудтэй энх тайван найрамдлын дуу хоолойгоо нийлүүлэх болов. 1953-1959 онд Бухарест, Варшав, Москва, Вена хотуудад болсон Дэлхийн залуучууд оюутны наадмуудад Монголын залуучууд амжилттай оролцсон юм.

1961 онд МХЗЭ-ийн 40 жилийн ойг тохиолдуулан бүтээн байгуулалтын үйлсэд Монголын залуучуудын оруулсан хувь нэмэр, гавьяа зүтгэлийг үнэлж, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар Сүхбаатарын одонгоор шагнасан байна.

VIII. Залуучууд социализмын материал техникийн бааз байгуулахын төлөө

1961-1988 онд МХЗЭ-ийн ХИҮ-ХИХ их хурлууд хуралдаж, тухайн цагийн бүтээн байгуулалтанд залуучуудын хүч анхаарлыг төвлөрүүлж байв.

МХЗЭ-ийн эгнээ өргөжиж, зохион байгуулалтын хувьд бэхжин, залуучуудын тухайд хэрэгжүүлэх төрийн гол үүргийг өөртөө шууд хариуцан гүйцэтгэх болов. МХЗЭ хууль санаачлах эрх бүхий субъектүүдийн нэг болсон байна. МАХН-ын ТХ-ны дэргэдэх Намын дээд сургуулиар ХЗЭ-ийн удирдах ажилтнуудыг бэлтгэх болов.

Монголын пионерийн "Залгамжлагч" анхдугаар чуулганыг зохион байгуулж, баатарчуудын байгууллагыг бий болгожээ. 1958 онд Монголын пионер сурагчдын ордныг байгуулж, 1984 онд эл ордны шинэ барилгыг ашиглалтанд оруулсан байна. Мөн хүүхэд залуучуудын "Найрамдал" паркийг байгуулсан нь өсвөр үеийнхэний амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх гол төв болжээ.

Түүнчлэн 1978 онд Олон улсын "Найрамдал" зуслан нээлтээ хийж, улмаар 1981 онд өргөтгөл хийснээр жилийн дөрвөн улиралд үйл ажиллагаа явуулах бололцоотой болж, өдгөө ч амжилттай ажилласаар байна. Ийнхүү залуучуудын байгууллагын соёл-хүмүүжлийн ажил зохион байгуулах материаллаг бааз бэхжиж байлаа.

1960, 1970-аад онд Монголын залуучууд ХАА-н үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хэд хэдэн томоохон үйлсийг оройлон манлайлав. Энэ үед "Эвлэлийн илгээлт" нь залуучуудын алдар гавьяаны дуудлага, зоригжуулагч уриа болсон юм. 8,10-р анги төгсөж буй залуучуудын дунд "Мал маллах сайхан" уриан дор хөдөлгөөн өрнөж, эвлэлийн илгээлтээр МАА-н үйлдвэрлэлд гарч ажиллах болсон байна. Дурьдан буй үед "Мал аж ахуй бол залуучуудын гавшгай үйлс мөн" уриан дор 50 мянган охид хөвгүүдийг ХАА-н үйлдвэрлэлд ажиллуулах нэр хүндтэй, хариуцлагатай үүргийг МХЗЭ өөртөө хүлээж байсан юм. Илгээлтээр ажиллаж буй залуучуудын хөдөлмөрийн амжилт бүтээлийг үнэлэх, мал маллах арга ухааныг хэрхэн эзэмшиж байгааг дүгнэх зорилгоор "Илгээлтийн эздийн чуулга уулзалт"-ыг тогтмол зохиож байв.

Монголын залуучууд атрын хоёр дахь аяныг зохион байгуулж, Найрамдал, Атар, Чандгана, Магсаржав зэрэг 10 гаруй САА байгуулж, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулжээ. МХЗЭ-ийн гишүүд атрын аян зохион байгуулж, алтан тариа найгуулахын зэрэгцээ "Хоёр дахь атар" болох говь нутгийг усжуулах ажилд орсон билээ.

1961 оны ҮI сарын 20-ны өдөр "Усгүй говь бидний гарт" гэсэн уриа лоозон хадсан олон арван машины цуваа Монголын залуучуудын ордны өмнөх талбайгаас алтан говийг зорин хөдөлсөн юм. Говь усжуулах анхны цуваанд их, дээд сургуулийн оюутан, техникумын сурагчдын төлөөлөгчид зуу гаруй хүн оролцжээ.

Түүнчлэн 1960, 1970-аад онд бог малыг хоёр ээлжийн, үхрийн 70 хувийг дулаан хашаа саравчаар хангах, малын тэжээлийн баазыг өргөтгөх, нам, засгийн бодлогыг хэрэгжүүлэх үйлсийн тэргүүн эгнээнд МХЗЭ-ийн гишүүд хөдөлмөрлөж байв.

Монголын залуучууд ЗХУ болон социалист бусад орны барилгачин залуустай хамтран Дархан хот, Шарын голын нүүрсний уурхай зэрэг томоохон хот, суурин үйлдвэр, аж ахуйн газруудыг барьж байгуулсан юм.

Эрдэнэтийн зэс молибдений уулын баяжуулах комбинатыг барьж байгуулахад олон зуун залуус эвлэлийн илгээлтээр ажиллан хүч чармайлтаа сорьж, шинэ техник технологийг эзэмшин, залуу насны хийморь цог золбоогоо бадруулж байлаа.

Энэ явцад барилгачдын тэргүүний бригадад олгох МХЗЭ-ийн Төв Хорооны шилжин явах тугийг бий болгож, хүндэт дэвтэрт бичин, ЗХУ болон бусад орнуудад МХЗЭ-ийн илгээлтээр явуулж ажиллуулж, туршлага судалж байв.

1970-аад оны эхээр ажилчин залуучуудын дунд "Гавшгай бригад" байгуулж ажиллах хөдөлгөөн өрнөв. Мөн оюутан, сурагчдын дунд гавшгай отрядууд, намрын ургац хураалтанд тогтмол оролцох болов. МХЗЭ-ийн байгууллагууд "Бага зардлаар чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэе", "6 өдрийн ажлыг 5 өдөрт хийцгээе", "Залуучуудаа! ширхэг эрэг, чимх будаа, дусал бензин хэмнэе" гэсэн уриа дэвшүүлэн, амьдралд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байлаа. 1975 онд МХЗЭ-ийн малчин гишүүд, залуучуудын дунд ариун цэвэр, соёлжилтоор хэвшүүлэх зүйлсийн жагсаалт, соёлч суурь, айл өрх шалгаруулах болзол зарлаж, тэргүүний залуу гэр бүлд "Соёлч суурь өрхийн гэрчилгээ" олгож байв.

Пионер сурагчдын дунд "Таван онцын эзэн" хөдөлгөөн өрнөж, залуу үеийнхнийг номтой нөхөрлүүлэх зорилгоор "Д.Нацагдорж" тэмдгийн болзол хангуулах ажлыг үргэлжлүүлэн зохиосон нь тодорхой үр дүнд хүрчээ.

МХЗЭ-ийн 50 жилийн ойгоор "Соёл Эрдэнэ" хамтлаг байгуулагдаж, түүний нээлтийн хөтөлбөрт эстрадын чиглэлийн дуу дуулсан нь хөгжмийн урсгалд эргэлтийн шинжтэй үйл явдал байлаа. 1975 оны IX сард эвлэлийн гишүүд нь орон сууц, албан байгууллагынхаа ойролцоо цэцэг тарих, таримал цэцгийн ямар нэгэн төрөл зүйлийг залуучууд өрсдөө бий болгох хөдөлгөөн өрнүүлж, жил бүрийн VIII сард цэцгийн үзэсгэлэн зохион байгуулдаг уламжлалтай болсон байна. Гудамж талбайд нэг, олон наст цэцгийн үрийг тарих, үрийг нь түүх ажлыг жил бүр тогтмол хийж залуучуудын нэрэмжит гудамж талбайг бий болголоо. Мөн залуучуудын чөлөөт цагаараа хийвээс зохих ажлын жагсаалтыг гарган, "Залуу орчуулагчдын дугуйлан", "Үзвэрийн сургууль", "Гэрэл зураг, кино сонирхогчдын клуб", "Үндэсний хөгжмийн хамтлаг", марк, цэцэг, загас сонирхогчдын сайн дурын нэгдлүүдийг бий болгож байсны зэрэгцээ байгууллагаараа цаначин, тэшүүрчин, усчин, хадланчин, жимсчин болох хөдөлгөөнийг өрнүүлэх зэргээр залуучуудын чөлөөт цагийг үр дүнтэй зүйлд зарцуулах, ялангуяа улс ардын аж ахуйн хэрэгцээтэй уялдсан ажилд чиглүүлэхийг голлон анхаарч байжээ.

1960, 1970-аад онуудад МХЗЭ-ийн гадаад харилцаа өргөжиж, олон улсын тавцан дээр нэр хүнд нь өсчээ. Энэ үед Монголын залуучууд дэлхийн оюутан залуучуудын Варшавын, хөдөөгийн залуучуудын, Венийн, Ази, Европын залуучуудын Москвагийн хоёр удаагийн уулзалтууд болон олон улсын хүүхдийн байгууллагын сургалт, семинаруудад удаа дараа амжилттай оролцсон юм. 1967 онд Олон улсын оюутны холбооны IX их хурал Улаанбаатар хотноо хуралдаж, дэлхийн 80 гаруй орны оюутны 115 байгууллагын төлөөлөгчид оролцжээ.

1979 онд Монгол, Германы залуучуудын I их наадам зохион байгуулсан байна.

1967 онд залуу үеийг эх оронч, интернациональч, ахмад үеийнхний хувьсгалт дайчин, хөдөлмөрч уламжлал, Монгол Зөвлөлтийн ард түмний найрамдал нөхөрлөлд чин үнэнч үзэл санаагаар хүмүүжүүлэх зорилгоор хойт хил орчмын 6 аймгийн нутаг дэвсгэрт Монгол-Зөвлөлтийн тойрон аялал зохиожээ. Үүнээс эхлэн Монгол-Зөвлөлтийн залуучуудын чуулга уулзалт, тойрон аялал, найрамдлын уламжлалт их наадмыг нийт 8 удаа хийсэн байна. 1969 оноос эхлэн жил бүр уламжлал болгон явуулдаг Монголын залуучуудын тойрон аялал чуулга уулзалт чухал ач холбогдолтой арга хэмжээ болж байна. Анхны аялалаар Халх голын 30 жилийн ойд зориулан дайчин баатарлаг эрсийн нэрсийг тодруулж, алдрын багана босгосон байна. Үндэсний тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэж байгаа Ази, Африк, Латин Америк зэрэг орны залуучуудын үйл ажиллагааг цаг ямагт дэмжин, тэдэнд сэтгэл санаа, эд материалын дэмжлэг үзүүлж, залуус тэмцэж байгаа Вьетнамд биеэр очиж байлдахад бэлэн байгаагаа илэрхийлж байв. Тийнхүү Вьетнамын баатарлаг ард түмэн, түүний залуу үеийнхэнд туслах хөдөлгөөн Монголын залуучуудын дунд өрнөж байсан юм.

Залуучуудын байгууллага, залуучуудын хөдөлгөөний ажил үйлсийг сурталчлах, мэдээлэл түгээх хүмүүжүүлэх хэрэгт "Залуучуудын үнэн", "Пионерийн үнэн", "Залуу үе", "Залгамжлагч" зэрэг хэвлэлүүд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

1971, 1981 онд Монголын залуучууд байгууллагаас залуу үеийг ахмад үеийн хувьсгалт дайчин, хөдөлмөрч уламжлалаар хүмүүжүүлэх болон бүтээн байгуулалтанд оруулсан гарамгай гавьяаг нь тэмдэглэж, Д.Сүхбаатарын одонгоор 3,4 дэх удаагаа шагнажээ. Энд тэмдэглэхэд, монголын залуучуудын хөдөлгөөний түүхнээ 1958-1978 онд МХЗЭ-ийн Төв Хорооны I нарийн бичгийн даргаар ажилласан Ч.Пүрэвжав томоохон үүрэг гүйцэтгэсэн юм. Энэ тухай 1975-1984 онд МХЗЭ-ийн Төв Хорооны I нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Л.Түдэв: "Эх орны аль хэрэгцээтэй гэсэн газарт эсвэл залуу хүний эрчим хүч, дайчин идэвх шаардлагатай гэсэн газарт Эвлэлийн илгээлтээр очиж ажиллах хөдөлгөөнийг орон даяар зохион байгуулахад Ч.Пүрэвжавын хүчин зүтгэл ихээхэн үүрэгтэй байлаа. Налайхын уурхайгаас эхлээд Дархан, Эрдэнэтийн бүтээн босголтын анхны тоосгыг илгээлтийн эзэн залуучууд тавьсан бөгөөд тэдгээрийн

илгээлтэн дээр Ч.Пүрэвжавын гарын үсэг үлдсэн юм... Монгол улсын тусгаар тогтнолын баталгаа болсон залуу үеийнхнийг насан туршдаа манлайлж, хойч үеийнхний өмнө бүдгэршгүй гавъяа байгуулсан Чойжилын Пүрэвжав хүний атрыг сэрээж, газрын атрыг хагалсан баатарлаг үйлстэн яриагүй мөн" /13,174/ гэжээ.

1980-аад он бол Монголын залуучуудын хувьд шинийг сэдэж, шинэ сэтгэлгээ буйлан төлжиж эхэлсэн жилүүд байлаа. Залуус 1987 онд Улаанбаатар хотод троллейбусны зам шугам, Хар айраг, Сайншандын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, Хөвсгөлийн Эрдэнэбүрэнхааны фосфоритын цогцолбор зэрэг олон шинэ барилга байгууламж дээр гавшгай хөдөлмөр өрнүүлж байв. МХЗЭ-ийн 60 жилийн ойгоор Эвлэлийн гишүүд залуучууд Эрдэнэт, Салхит, Багануур, Багахангай, Чойрын төмөр замыг байнгын ажиллагаанд оруулж, Булган, Хархориний өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамыг МХЗЭ-ийн гавшгай хөдөлмөрийн фронт болгон босгон сүндэрлүүлээ.

МХЗЭ-ийн илгээлтээр хөдөөд 1000 гаруй залуучууд, ТМС төгссөн 50 гаруй мянган залуу ажилчид аж үйлдвэр, дэд бүтцийн салбарт ажиллаж байв. Монголын залуучууд олимп, тив, дэлхийн аварга шалгаруулах уралдаан тэмцээнд алт, мөнгө хүрэл медаль хүртэж, улс Монголынхоо төрийн далбааг мандуулж, сүлд дууллаа эгшиглүүлж ирсэн юм.

Улс төрийн дууны наадам, ШОУ зэрэг шинэ хэлбэрүүд дэлгэрчээ. Гэвч МХЗЭ-ийн бүх шатны байгууллагуудын ажилд хэлбэрдэх, лоозогдох, сүржигнэх явдал газар авч, улам бүр олон нийтийн байгууллагын бие даасан шинжээ алдаж байв. МАХН залуучуудын байгууллагын дотоод хэрэгт шууд хутгалдан орж, боловсон хүчнийг нь шууд мэдэж, улс төр, үзэл суртлын хяналт тавих болсон юм. Манай залуу үеийнхний шинэ сэтгэлгээтэй хэсэг нийгэмд бугшсан архаг үзэгдүүдийг анх түрүүн мэдэрч өөрчлөлт шинэчлэлтийн замыг сонгосон билээ.

IX. Залуучууд ба өөрчлөлт, шинэчлэлт

1980-аад оны сүүлч 1990-ээд оны эхээр Монгол оронд өөрчлөлт шинэчлэл хүчтэй өрнөжээ. Шинэ сонголт, ардчилсан хөдөлгөөнийг Монголын залуучууд оройлон манлайлсан юм. 1989 оны XI сарын сүүлчээр чуулсан Залуу уран бүтээлчдийн улсын II зөвлөлгөөнд оролцогчид Монголын нийгмийн өмнө тулгамдсан асуудлаар санал бодлоо зоригтой илэрхийлж, уг зөвлөлгөөнд оролцсон хэсэг залуучууд улс орон дахь өөрчлөлт шинэчлэлийг эрчижүүлэхэд тус дөхөм үзүүлэх зорилготой шинэ байгууллага бий болгох болсноо албан ёсоор зарлажээ. Ингэж Монголын Ардчилсан Холбоо байгуулагдсан юм. Түүний дараа олон шинэ хөдөлгөөн, байгууллагууд үүдэн бий болж, уламжлалт олон нийтийн байгууллагууд үзэл санаа, үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг шинэчилжээ. Тухайлбал: 1990 оны IV сард хуралдсан МХЗЭ-ийн онц их хурал "МХЗЭ-ийг бие даасан үйл ажиллагаатай улс төрийн хүчин" /14/ гэж зарласан нь айсуй цагийн өнгө төрхийг ойлгож, ардчилал шинэчлэлийн үйлсэд идэвхитэй оролцохоо илэрхийлсэн хэрэг байлаа. Гэвч Монголын залуучууд түүний удирдлаган дор МАХН-ын бэлтгэл хүчин, залгамж халаа хэвээр байж, ардчилсан хөдөлгөөнд оролцох уу, аль нэг улс төрийн намаас хамааралгүй зарчмын цоо шинэ бие даасан төрийн бус байгууллага болж, өөрчлөлт шинэчлэлийн үйлсэд хувь нэмэр оруулах уу хэмээх асуудлаар санал зөрж байв 1991 оны I сард хуралдсан МХЗЭ-ийн XX их хурал залуучуудын шинэ байгууллагыг зохион байгуулах чуулганаас МХЗЭ-ийн 70 жилийн түүхэнд үнэлэлт, дүгнэлт өгсөний дээр тус байгууллагын үйл ажиллагааг зогсоож, түүний бааз суурин дээр зарчмын шинэ байгууллага-Монголын Залуучуудын Холбоог байгуулсан байна.

Тус их хурал Монголын Залуучуудын Холбоонд МХЗЭ-ийн түүхэнд уламжлалыг ирж буй цагийн шинэ утга агуулга, орчин цагийн дэлхийн залуучуудын хөдөлгөөний хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн үргэлжлүүлэх хүндтэй бөгөөд нэн хариуцлагатай үүргийг ноогдуулсан юм. Энэ бол Монголын залуучуудын хөдөлгөөний түүхийг зогсоосон хэрэг биш уламжлал шинэчлэлийн дундаас утга нээн, үр соёолуулсан явдал, "Өнгөрсөн бүхэн эхлэл" хэмээх түүхэн жам ёсыг гүнзгий ухаарсны хаялга байлаа.

МЗХ байгуулагдсанаар Монголын залуучуудын хөдөлгөөний түүхийн шинэ үеийн эхлэлийг тавьсан билээ. Залуучуудын зарчмын шинэ байгууллага залуу үеийнхнийг үзэл бодлоор нь үл ялгаварлаж, нийтлэг эрх ашгийг нь илэрхийлж хамгаалах зорилго дэвшүүлэн ажиллах болсон юм.

Залуучууд үзэл бодол, хүсэл сонирхол, эрх ашгаараа чөлөөтэй эвлэлдэн нэгдэж, залуучуудын янз бүрийн байгууллага хөдөлгөөнийг үүтгэн бүтээлч үйл ажиллагаа өрнүүлэх болсон нь залуучуудын хөдөлгөөнийг монополь байдлаас чөлөөлсний үр дүн, залуучуудын хөдөлгөөн сонгодог утгаараа хөгжих болсны нотолгоо юм. Тус холбоо анхныхаа их хурлаар МЗХ-ны бэлгэ тэмдгийг батлан гаргажээ.

Монголын Залуучуудын Холбоо үүсэн байгуулагдсан цагаасаа хойш төрөөс залуучуудын талаар баримтлах шинэ бодлогын үндсийг бүрдүүлэх, залуу хүн бүр өөрийн болон улс орныхоо төлөө тодорхой зорилго тэмүүлэлтэй ажиллаж, амьдрах сэтгэлгээг төлөвшүүлэх, ардчилал, зах зээлийн нөхцөлд залуучуудад үлгэрлэн дууриах тодорхой хэвшил үзэл санааг бий болгох, шинэ зуунд Монгол улсын хөгжлийг тэргүүлэн авч явах, нийгэм, улс төр, эдийн засгийн салбарын залуу удирдагчдыг тодруулан гаргах, залуучууд, залуу гэр бүлд дэмжлэг тусалцаа үзүүлэх, залуучуудын гоо зүй ёс суртахууны түвшинг дээшлүүлэх, тэдний чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, залуучуудын солилцоог хөгжүүлэх, Монголын залуучуудын байгууллагыг олон улсын залуучуудын хөдөлгөөний нэр төртэй гишүүн байгууллага болгох зэрэг чиглэлээр тодорхой бодлого зорилготой, идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна. /15/

Монголын Залуучуудын Холбооноос дэвшүүлэн гаргасан “Шинэ үе, шинэ бодлого”, “Монгол хүний эрхэмлэх 9 зүйл”-ийг ард түмэн, залуучууд дэмжин ажиллаж байна. Тэрхүү 9 зүйлд: “Би туулж өнгөрүүлсэн амьдралаа эргэж харах үед харамсах зүйл гарахгүй байхаар амьдарна. Ингэхийн тулд:

1. Би-Өөрийн авъяас билгийг нээн илрүүлж, нийгэмд зөв байр сууриа олно.
2. Би-Өөрийн бие бялдрыг хөгжүүлж, “Эрүүл биед саруул ухаан оршино” гэдэг зарчмыг мөрдлөг болгоно.
3. Би-Өөрийн мэдлэг боловсролоо дээшлүүлэн хөгжүүлж, мэдээллийг чадварлаг ашиглан, эд баялагийг буй болгоно.
4. Би-Өөрийн иргэний эрх, эрх чөлөөг хамгаалан зогсож, ардчилал, хууль ёсны төлөө тэмцэн, амьдарч буй нийгмээ жаргалтай, шудрага байлгахын төлөө байна.
5. Би-Өөрөө өөрийгөө, өрх бүлээ тэжээх чадвартай байж, айл гэрийн хийморь лундааг эрхэмлэн явна.
6. Ахмадынхаа өмнө өртэй, хойчийнхоо өмнө үүрэгтэй, “Гурван цагийн хэлхээс”. Бид дутагдах юмгүй, гачигдах зовлонгүй, жаргалтай ариун бүлийг буй болгон авч явна.
7. Эртний түүхт тусгаар Монголын голомтыг сахигч-Бид бие биедээ нөхөр байж, эх орноо хөгжүүлнэ, баяжуулна, хүчирхэгжүүлнэ.
8. Соёл иргэншилт хүн төрөлхтний тасархай-Бид бусдыг хүндэтгэж, бусдаар хүндэтгүүлж, хүнлэг бүрийг өөрийн гэж үзнэ.
9. Байгаль эхийн үр сад-Бид байгаль орчинтойгоо зохицож амьдарна” /16/ гэжээ.

МЗХ “Олон улсын залуучууд”-ын жилийн 10 жилийн ойн арга хэмжээний хүрээнд залуучуудыг дэмжин туслах хуультай болгох, төрөөс залуучуудын талаар баримтлах Үндэсний хөтөлбөр боловсруулах, “Монголын залуучуудын өдөр” бий болгох цогцолбор санал дэвшүүлснийг төр, засгаас дэмжиж, амьдралд хэрэгжиж байна.

Дэлхийн шилдэг байгууллагын цомыг аймаг, хот, сум дүүргээр аялуулсан нь залуучуудыг бүтээлч ажил хөдөлмөрт уриалан дуудаж, шинэ эрч, зориг хүчийг өгсөн юм. Монгол Улсын Засгийн газраас 1998 оныг “Залуучуудын жил” болгон зарласан нь залуусын урам зоригийг бадрааж, улс орны хөгжил, нийгмийн амьдралд залуучуудын оролцоог идэвхижүүлж өгөв.

МЗХ-ны II Ерөнхий чуулганаас 21 аймаг, нийслэл дүүргийн нийт салбар зөвлөлүүдийн дунд зарласан “Шинэ үе-Шинэ бодлого” урамшуулалт уралдааныг “Залуучуудын жил”-ийг тохиолдуулан дүгнэв. МЗХ улс орны өмнө тулгарсан нийгмийн

асуудлыг шийдвэрлэхэд залуучуудын хүчийг төвлөрүүлж байна. Өнгөрсөн 10 жилүүдэд Монголын Залуучуудын Холбоо ДОХ-той тэмцэхэд залуучуудын байгууллагын оролцоо 4 сарын аянг зохиож, цас зуд, байгалийн гамшигт өртөж буй малчдад туслах зорилгоор “Залуу малчин” хөдөлгөөн өрнүүлэв. Мөн МЗХ-ны дэргэд залуучуудын Сургалт, судалгааны “Полиси” төв, Хөдөлмөрийн бирж байгуулж, залуучуудыг ажлын байраар хангах арга хэмжээ авч байна.

Түүнчлэн МЗХ-ноос “Залуу удирдагч сан” байгуулж, нийгэм улс төр, эдийн засаг бизнесийн салбарт амжилттай ажилласан “Оны залуу”-сыг шалгаруулдаг уламжлал тогтлоо. Анхны “Оны залуу”-гаар Монголын Хөрөнгийн биржийн захирал Н.Золжаргал, УИХ-ын гишүүн, МАХ-ны ерөнхий зохицуулагч Ц.Элбэгдорж нарыг тус тус шалгаруулсан байна. МЗХ-ноос Ахмадын жил, Халх голын ялалтын 50 жилийн ойд зориулан ахмад дайчдад хүндэтгэл үзүүлж “Гурван үеийн чуулга уулзалт”, “Мансууруулах бодис зүй бусаар хэрэглэж байгаатай хэрхэн тэмцэх тухай” үндэсний зөвлөлгөөнийг зохион байгуулсан юм. МЗХ оюутан залуусын дунд зохиох ажлаа улам идэвхижүүлэх болов. 1993 онд намрын тариа хураалтын оролцож буй оюутан сурагчид, тариаланч, механикжуулагчид зориулж ухуулга, сурталчилгааны ажил зохион байгуулсан нь ихээхэн үр дүнтэй болсон юм. Мөн Дархан, Эрдэнэт хотын Залуучуудын Холбоотой хамтран “Оюутны үдэш-94” тоглолтыг санаачилан зохион байгуулсан байна.

Багш, оюутны эрдэм шинжилгээний “Эврика” бага хурлыг 1997 оноос эхлэн зохион байгуулсан нь эдүгээ уламжлал болжээ. 2000 онд Монгол улсын шинэ Засгийн газартай хамтран ажиллах “15 багц санал”-ыг МЗХ-ноос өргөн барьж, хэрэгжүүлж байна. Түүнчлэн МЗХ-ноос монголын залуучуудын хөнгөлөлтийн картыг санаачлан, нийгмийн үйлчилгээний салбаруудад нэвтрүүлжээ. Дэлхийн хүн амын өдрийг тохиолдуулан МЗХ-ноос санаачлан Сэлбэ голын сав газрыг цэвэрлэх компанит ажлыг хийсэн байна. Мөн “Шинэ үеийн илгээлтийн эзэд”-ийн төслийг санаачилснаар хөдөөд шаардлагатай байсан эмч, багш нар 13 аймгийн суманд гаруй хүн илгээлтийн эзнээр ажиллаж байна.

Монголын залуучуудын байгууллагын гадаад харилцаа өргөжиж, олон улсын нэр хүнд эрс өсчээ. МЗХ 1993 оны IY сард Дэлхийн Залуучуудын Ассамблейн YIII сард Азийн Залуучуудын Зөвлөлийн жинхэнэ гишүүнээр тус тус элссэн байна. 1992 онд МЗХ Английн “Ралей интернэшнл” болон өөрийн орны холбогдох байгууллагуудтай хамтарч, Ховд аймагт “Амарсанаа” олон улсын залуучуудын аян, түүнчлэн Улан-Үд хотноо Монгол туургатан залуучууд, оюутан II их наадмыг зохион байгуулахад оролцжээ. МЗХ олон улсын залуучуудын байгууллагын хурал, зөвлөлгөөнд оролцож, эх орондоо хэд хэдэн арга хэмжээг зохион байгуулсан байна. 1994 оны XII сард Сөүл хотноо ЮНЕСКО-ийн залуучуудын төв болсон Ази, Номхон далайн орны засгийн газрын бус, залуучуудын байгууллагын I зөвлөлгөөнд МЗХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Зоригтбаатар оролцсон юм. 1997 онд Монголын залуучуудын төлөөлөгчид Азийн залуучуудын урлагийн их наадам, “Ази, Номхон далайн залуучуудын хөтөлбөр” Ази, Номхон далайн орнуудын залуучуудын чуулгауулзалтанд амжилттай оролцлоо. 1993 оны YIII сард Улаанбаатар хотноо Ази, Номхон далайн орнуудын залуучуудын “Унаган байгаль” зуны зуслан семинар болж, Индонез, Балбын вант улс, Малайз, Пакистан, Энэтхэг, Хятад, Фижи, Монгол улсын нийт 100 гаруй төлөөлөгчид оролцжээ. Мөн 1994 оны YIII сард Ази, Номхон бүс нутгийн залуучуудын томоохон байгууллага болох АЗЗ-ийн YI хурлыг Монголд анх удаа зохион байгууллаа. 2000 онд Монголд олон улсын хөдөлмөр зуслан ажиллаж АНУ, Япон, Өмнөд Солонгос, Их Британи, Франц, Итали, Сингапур, Словен зэрэг орны 20 гаруй сайн дурынхан оролцов. Мөн онд манай оронд Бүх Хятадын Залуучуудын Холбооны төлөөлөгчид, Солонгосын оюутан залуучуудын төлөөлөгчид айлчилсан нь МЗХ-ны олон улсын нэр хүнд өсч, гадаад харилцаа өргөжиж байгаагийн тод илрэл болов.

Монгол улсад залуучуудын хөдөлгөөн үүсч хөгжсөний 80 жилийн ой, МЗХ-ны 10 жилийн ойн нэрэмжит “Залуустайгаа 80 жил” бүтээлч аяныг орон даяар зарлан дүгнэсэн юм.

Монголын залуучуудын хөдөлгөөний түүхт 80 жилийн ойг ойг улс орон даяар ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлээ.

Оны залуугаар шалгарсан шилдэг тэргүүний залуучууд манай орны улс төр, эдийн засаг бизнесийн хөгжлийн өнгө төрх, цаашдийн хандлагыг тодорхойлж, билэг оюун эрдэм ухааныг дээдэлсэн XXI зуунд Монголын залуучууд дэлхийн түвшинд өрсөлдөж байна хэмээх чиглэл бүхий байна.

Өдгөөгийн Монголын залуучууд эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулах их үйл хэргийн хүндийн төвийг үүрч, ахмад үеийнхээ хөдөлмөрч уламжлалыг нэр төртэй үргэлжлүүлж даяаршлалд адилсах, ондоосохын тэгш хэмийг зохиролдуулан хичээнгүйлэн зүтгэж байна.

Залуу нас-гал халуун амь
ганхиралыг үл тоох
дэврүүн сэтгэл

Залуу нас-эгэлгүй эрч хүч
эрэмгий зоригийн
ширгэшгүй ундраа

Залуу нас-сэрэх ухааны дуудлага,
сэдэн олох
шинэ сэтгэлгээ

Залуу нас-хийж бүтээхийн хүслэн,
хэрэгжүүлэх их
үйлсийн эзэн

Мохошгүй, бөхөшгүй,
өнөд үргэлжлэх
залуу нас

Мөрөөдөл итгэл
дүүрэн даах
Монгол залуус

Мөнхийн цэл залуугаараа
Монголын сайхан
эх орон мину.

“To the issue of Mongolian Youth movement history”

Summary

By J. Boldbaatar.

To the issue of Mongolian Youth movement. The foundation for Mongolian youth movement was established in 1921, 25th August with great ion of Mongolian Revolutionary Youth League. In 1920's. Youth organization has been trying to challenge the puling MPRR.

In the peril of 1930-1990, MRYL became the assistant vestures of MPRP and contributed a lot to the building new society.

Since 1990 in reformation times MVO heard.

Эшлэл, зүйлт

1. НТА. Ф-1, Д.23, хн-133.
2. "Хураангуй сэтгүүл" сонин. 1922. №10-11
3. Залуучуудын олон их, бага хурлуудын тухай эмхтгэсэн дэвтэр. УБ.
4. Ойдов, Цэцэнбилэгт. МХЗЭ-ийн түүхэнд холбогдох зүйлүүд. УБ., 1926.
5. Коммунист ба Монгол. УБ., 1999.
6. "Үнэн" сонин. 1926. VIII.11. №8
7. Б.Жамбалдорж. Түүхийн өдөр, шөнө. "Монголын залуучууд" сонин. 1990. №133.
/дам иш татав/
8. МХЗЭ-ийн түүхэнд холбогдох зарим баримт бичгүүд. 1921-1940. УБ., 1972.
9. Ж.Болдбаатар. "Миний хоцрогдсон"-ыг дэлхий мэднэ. Булган. 1994.
10. "Залуучуудын үнэн" сонин. 30 /1940/ оны V сарын 21. №32.
11. Улс төрийн дуу. УБ., 1985.
12. НТА. Ф-4, т-23, хн-3.
13. Б.Жамбалдорж. Залуусыг дагуулсаар... хорин жил. УБ., 2000
14. "Залуучуудын үнэн" сонин. 1990.IV.
15. Монголын залуучуудын холбооны архив. МЗХ үүсэн байгуулагдсны 10 жилийн ойн баярын хуралд Ц.Зоригтбаатарын тавьсан илтгэлээс.
16. Монголын Залуучуудын Холбоо. /Танилцуулга/. УБ., 2001.